

“Шалгалтыг үнэлэх программ хангамж, тоног төхөөрөмжийг сайжруулах” хөтөлбөр

Хэрэгжүүлэх үндэслэл

Боловсролын үнэт зүйлс, үр дүнг үнэлж, хэмжих асуудал өнөөдөр нийтийг хамарсан глобаль асуудлуудын нэг бөгөөд боловсролын үнэлгээний үр дүнгийн талаар мэдээлэл цуглуулж, түүндээ боловсруулалт, дүн шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт өгч, дэвшилтэй зүйлсийг баталгаажуулж, гажуудлыг зохистой үед нь илрүүлэн засаж сайжруулах явдал нь үнэлгээний бодит байдлыг дээшлүүлэх гол хүчин зүйл юм. Үнэн зөв, бодитой үнэлгээ нь сургалтын агуулга, арга технологийг боловсронгуй болгон хөгжүүлэхэд чухал түлхэц болдог нь боловсролын үнэлгээний хөгжлийн явц, олон улсын туршлагаас харагдаж байна.

Иймээс элсэлтийн ерөнхий шалгалтын зохион байгуулалт, шалгалтын сэдэв боловсруулах, материалыг дүгнэхдээ олон улсын аргачлалын дагуу сүүлийн үеийн технологи, программ хангамж ашиглан үнэлдэг бөгөөд үнэлгээний чадвартай мэргэжилтнүүдийг сургалтад тогтмол хамруулан, мэдлэг чадварыг нь байнга дээшлүүлж байх шаардагатай юм.

Их, дээд сургуулийн элсэлттэй холбоотойгоор хийгдэж буй томоохон шинэчлэл болох элсэлтийн ерөнхий шалгалтыг БСШУЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төв бие дааж, холбогдох байгууллагуудын дэмжлэгтэйгээр 2006 оноос эхлэн зохион байгуулж ирсэн.

БСШУЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төв нь бүх шатны боловсролын байгууллагуудад үнэлгээ хийж, элсэлтийн ерөнхий шалгалтыг улсын хэмжээнд зохион байгуулдаг бөгөөд үнэлгээний материалыг засах, боловсруулах үйл ажиллагаанд АНУ-ын Скантрон компанид үйлдвэрлэсэн техник технологийг ашигладаг. Өнөө үед шинжлэх ухаан, техник технологи эрчимтэй хөгжиж буй энэ цаг бид шалгалтыг үнэлэх зарим үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах шаардлага зайлшгүй урган гарна.

Боловсролын бүх шатны байгууллагыг үнэлэх болон элсэлтийн ерөнхий шалгалтын арга, технологийг боловсронгуй болгох зорилготойгоор “Шалгалтыг үнэлэх программ хангамж, тоног төхөөрөмжийг сайжруулах” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэ нь эцсийн дүндээ Монгол Улсын боловсролын үнэлгээний системийн үйл ажиллагааг сайжруулахад бодитой хувь нэмрээ оруулах арга, ажиллагаа болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Зорилго

Боловсролын үнэлгээний төвийн үйл ажиллагааны хүрээг өргөтгөн боловсролын бүх шатны байгууллагуудыг үнэлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор үнэлгээний аргачлалыг шинэчлэх техник тоног төхөөрөмж, шалгалтын материал засах, технологийг сайжруулах, эдгээр ажлуудад мэргэжилтнүүдийг сургах, бэлтгэх, шалгалт, судалгааг нууцлалын өндөр зэрэглэлтэйгээр зохион байгуулах, судлах, үнэлэх үйл ажиллагааг чанарын шинэ түвшинд гаргахад оршино.